

**АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ**

Огноо	2024 оны 4-р сарын 27-ны өдөр
Цаг	11:00
Байршил	Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сэнтрал Тауэр, 17 давхар
Хурлын дарга	Ч.Ганхуяг
Хурлын ирц	53.84%
Нийт хувьцааны тоо, саналын эрх	Хавсралт 1
Нарийн дарга	Бичгийн С.Нямгэрэл
Хэлэлцэх асуудал	- Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах; - Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах; - Компанийн 2023 оны санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах; - ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах; ТУЗ-ийн төсвийг батлах; - Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

Хурлын нээлт:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ын дэгийг Б.Золбоо танилцуулав.

Хувьцаа эзэмшигчид: Хурлын дэгт холбогдуулан санал, хүсэлт гаргаагүй болно.

Тооллогын комиссын дарга О.Нандинцэцэг хурлын ирцийг танилцуулж, Хурал хүчин төгөлдөр болсныг зарлав.

Хурлын дарга Ч.Ганхуяг нь Хурлыг нээж, Компанийн Хурал албан ёсоор эхлэв.

1. КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАХ

Б.Золбоо нь Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайланг тавьж, 2023 онд болсон онцлох үйл явдлуудыг дурдав. Түүнчлэн, Б.Золбоо нь ТУЗ-ийн гишүүд болон удирдлагын баг, нэгдлийн бусад компаниудын удирдлагуудыг тус тус танилцуулсан болно.

Х.Билгүүн нь 2023 санхүүгийн тайлан, аудитын тайлан, арилжааны мэдээ зэргийг тус тус танилцуулав.

2. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХ ЭСЭХ ТУХАЙ ТУЗ-ИЙН ШИЙДВЭРИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Б.Золбоо нь ногдол ашиг хуваарилах эсэх ТУЗ-ийн ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг танилцуулав.

3. КОМПАНИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ

3.1. Хөндлөнгийн тайлан

Грант Торнтон хөндлөнгийн аудитын тайланг тус аудитын компанийн Гэрээт ажлын партнер Н.Эрдэнэцог танилцуулав.

3.2. ТУЗ-ийн Дүгнэлт

Ч.Ганхуяг нь 2023 оны Санхүүгийн болон Үйл ажиллагааны тайлангийн талаарх дүгнэлтийг тунилцуулав.

ШИЙДВЭР: Компанийн 2023 оны Санхүүгийн болон Үйл Ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн Дүгнэлтийг батлах тухай тогтоолыг хавсаргав.

4. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГ ТАНИЛЦУУЛАХ; ТУЗ-ИЙН ТӨСВИЙГ БАТЛАХ

Ч.Ганхуяг ТУЗ-ийн Үйл ажиллагааны тайлан болон төсвийг танилцуулж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцсэн чухал асуудлуудыг мөн танилцуулав.

ШИЙДВЭР: ТУЗ-ийн төсвийг батлах тухай тогтоолыг хавсаргав.

5. КОМПАНИЙН ДҮРМИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА БАТЛАХ

С.Нямгэрэл нь Компанийн Дүрмийн шинэчилсэн найруулгын өөрчлөлт болон шинээр нэмэгдэж буй заалтуудыг тус тус танилцуулав.

ШИЙДВЭР: Компанийн шинэчилсэн найруулгыг батлах тухай тогтоолыг хавсаргав.

6. АСУУЛТ, ХАРИУЛТ

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн асуусан асуултад Ч.Ганхуяг, Б.Золбоо нар нь зохих тодруулгыг өгсөн болно.

7. САНАЛ ХУРААЛТ

Энэхүү Хуралаар хэлэлцсэн асуудлуудад холбогдох санал хураалт явагдаж, Тооллогын комисс нь Хурлын санал хураалтын дүнг танилцуулав.

Хурлыг хааж Ч.Ганхуяг үг хэлэв.

Хурал дэгийнхээ дагуу 13:00 цагт өндөрлөсөн болно.

ДЭЭР ДУРДСАНЫГ ГЭРЧЛЭН, энэхүү тэмдэглэлийг баталгаажуулсан

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНХУЯГ